




**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛДЭГДЭЖ БҮРТГЭГДСЭН
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН АЖЛУУД**

2018.11.03-2018.11.16





БҮРТГЭГДСЭН ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ



2018.11.03-11.16 хүртэлх 14 хоногт нийт 21 гомдол мэдээлэл бүртгэгдсэн нь өмнөх 14 хоногийн үзүүлэлттэй харьцуулахад гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл 4 буюу 28,4 хувиар зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 5 буюу 31 хувиар нийт хүлээн авсан гомдол мэдээлэл **9 буюу 30 хувиар** тус тус буурсан үзүүлэлттэй байна.



ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ /2018.11.03-2018.11.16/

ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ





ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ





ҮЙЛДЭГДСЭН ГАЗАР

2018.11.03-11.16







ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ ӨНГӨРСӨН 14 ХОНОГТ

ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖТЭЙ

ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ



**ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, БУСАД АЖЛЫН
ТАЛААР**

“Галт зэвсэг-2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд галт зэвсгийн тооллого 25 хувьтай явагдаж байна.



ЦЕГ-ын даргын тушаалтын дагуу хариуцсан нутаг дэвсгэрт “Объект субъектын цахим судалгаа”-ны нэгдсэн сан бүрдүүлэх ажлын хэсгийг байгуулан алба хаагчдыг 5 баг болгон хувааж аймгийн хэмжээнд судалгааг гарган ажиллаж байна.

“Илрүүлэлт Оргодол-Шийдвэрлэлт-2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд хэрэг бүртгэлтийн 4 хэрэгт холбогдогчийг олж тогтоон яллагдагчаар татаж эрэн сурвалжилагдаж байсан 1 хүнийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон.

Аймгийн хэмжээнд “Бүрэн бус чиргүүлтэй ачааны автомашин” хэсэгчилсэн арга хэмжээг Авто тээврийн төвтэй хамтран зохион байгуулан ажиллаж байна.



Аймгийн Прокурорын газар, Шүүхийн шинжилгээний албатай хамтран “Гомдол мэдээлэл хүлээн авах, бүртгэх, хэргийн газарт шуурхай ажиллах үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал” сэдвээр Цагдаагийн хэлтсийн хурлын танхимд хэлэлцүүлэг зохион байгуулав.

Хэлэлцүүлэгт аймгийн Прокурорын газар, Шүүхийн шинжилгээний алба, Цагдаагийн хэлтсийн нийт 23 алба хаагч хамрагдсан.



“Эрүүл-Цагдаа” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран алба хаагчдын дунд “Зохистой хооллолт” сэдвээр 2 цагийн сургалт зохион байгуулж сахар, элэгний В. С вирусын шинжилгээнд алба хаагчдыг хамруулав.

Мөн алба хаагчдыг эрүүл чийрэг бие бялдартай болгох зорилгоор “Өөрчлөлтийг өөрөөсөө” сэдэвт тэмцээнийг 2 сарын хугацаанд зохион байгуулан ажиллаж байна.



Албаны сургалтын төлөвлөгөөний дагуу “Киберь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь”, “Төрийн албаны тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар алба хаагчдын дунд 4 удаа сургалт зохион байгуулав.

Алба хаагчдын ээлжит мэдээллийн цагаар 2 алба хаагч “Архины хор уршиг”, “Тамхины хор уршиг” сэдвээр бие бүрэлдэхүүнд мэдээлэл хийв.

Аймгийн Ерөнхий боловсролын 5 дугаар сургуультай хамтран “Албан бичгийн найруулга зүй” сэдвээр 1 цагийн сургалт зохион байгуулав.



Цагдаагийн хэлтсийн Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга цагдаагийн дэд хурандаа А.Азжаргал эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх албаны 80 жилийн ойгоор “Цагдаагийн гавъяа”, “Санхүү банкны тэргүүний ажилтан” тэмдгээр мөрдөгч Н.Дашдондог хугацааны цагдаагийн ахлах дэслэгч цолоор шагнуулав.





**Анхаарал хандуулсанд
баярлалаа.**